

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

АРВАЙХЭЭР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НАСАНЖАРГАЛ ОВОГТОЙ МӨНГӨНЦЭЦЭГ-ИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Гүйцэтгэлийн түвшин							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биел элти йн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. "ТҮҮХ, СОЁЛЫН ӨВӨӨ ХАМГААЛАН, ҮНДЭСНИЙ БАХАРХЛАА ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ, СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	"Бүх нийтийн соёлын боловсрол" дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллах	Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдагсадын тоог нэмэгдүүлнэ.	3900	10000	Аймгийн СУГазартай хамтран "Өвөрхангай урчууд-2024" уран шаглаа үзэсгэлэнд нийт давхардсан тоогоор 600 гаруй иргэн уран хатгамлын бүтээлүүдийн үзвэр үзэж, "Бүх нийтийн соёлын боловсролын өдрүүд" арга хэмжээнд 1100 гаруй иргэд оролцож, арга хэмжээнд хамрагдсан байна. Аймгийн ХДТеатр энэ оны 06 дугаар сарын байдлаар 23 урлагийн арга хэмжээнд нийт 5750 үзэгчдэд урлагийн үйлчилгээ үзүүлсэн урд оныхоос 47.4 хувийн өсөлттэй байна.	2024.01.10 2024.11.10	90
2	Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажилд байгууллагатай хамтран хяналт тавих	Хяналт шалгалтын тоогоор	2	1	Арвайхээр сумын хэмжээнд 15 түүх соёлын үл хөдлөх дурсгалыг /хиргисүүр/ хамгаалалтад байдаг бөгөөд 2024 оны байдлаар зөрчил, гэмт хэрэг илрээгүй байна. Улсын өв тээгчдийн бүртгэлд бүртгэсэн сумын биет бус өв тээгч 9 иргэний мэдээллийг баяжуулах, шинээр өвлөн уламжлагч биет бус өв тээгчдийг бүртгэх, баримтжуулаа.	2024.09.10 2024.11.05	80
3	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл судалгааг хийж, мэдээллийн санд баяжилт хийх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт	Хяналт шалгалтын тоогоор	-	1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг шинээр тогтоож мэдээллийн санд баяжилт хийхээр ШУА-ын археологийн хүрээлэнгээр судалгаа хийлгэж гүйцэтгүүлэн 300 гаруй олдворыг илрүүлсэн тайланг хүлээн авсан. Арвайхээр сумын түүх соёлын 6 хөшөө	2024.05.10 2024.09.10	90

	хамгаалалтад хяналт тавих, хамгаалах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах				дурсгалыг 360 градусын зураг, тайлбартайгаар виртуал аялалд оруулж сурталчлан таниулж байна.	
4.	Соёлын биет бус өвийн бүртгэл судалгааг хөтөлж, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлэх	Сургалт сурталчилгаа, арга хэмжээ тоогоор	-	1	Биет бус өв тээгч 18 иргэний бүртгэлийг маягыг шинэчлэн хийж цахимжуулсан. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд Ардын язгуур урлаг төрөлд Төв халхын уртын дуучин, хоолойн лимбэчин, хоолойн лимбэчин, өвлөн уламжлагч Р.Цэрэндэгид өв соёлоо сурталчлан оролцсон.	2024.08.01 2024.11.15 80
5.	"Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйлдвэрлэгч иргэдийн тоогоор	-	20	Соёлын үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор Өвөрхангайн урчууд" үзэсгэлэнг 2023 оноос эхлэн аймгийн СУГ-тай хамтран жил бүр зохион байгуулж арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ жил соёлын үйлдвэрлэл эрхлэгч иргэдээс уран хатгамлын төрлийг сонгож сумын хэмжээнд уран хатгамалч 11 иргэний судалгааг гаргаж "Өвөрхангайн урчууд-2024" үзэсгэлэнд оролцуулсан. Шилдэг уран хатгамалч, шилдэг борлуулалттай бүтээгдэхүүн урлаачдыг шалгаруулж, шагналд нийт 650,000 төгрөгийг зарцуулсан. Монгол гэрийн мод, сийлбэрийг уламжлалт хэв маягаар үйлдвэрлэдэг 17 иргэний судалгааг гаргаж, "Бүх нийтийн соёлын боловсролын өдрүүд" арга хэмжээнд оролцуулснаар иргэдэд үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээ сурталчлан, олон нийтэд хүргэснээр хагас жилийн байдлаар нийт 28 соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг сурталчлан таниулах арга хэмжээнд оролцуулаад байна.	2024.01.10 2024.11.10 80
6.	Биет бус өвийг өвлөн уламжлуулах шавь сургалтыг хөгжүүлж, шилдэг өвлөн уламжлагчдыг дэмжин, төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	Шавь сургалтыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан эсэх	-	1	Биет бус өвийн Ардын урлагийн Их наадамд. "БОЛОР2" хамтлаг 2 дахь удаагаа амжилттай оролцсон. Биет бус өв тээгч, үндэсний морин хуур хөгжмийн зэмсэг үйлдвэрлэгч, хөгжмийн багш Ц.Адьяахүүгийн үйлдвэрлэсэн 14 морин хуурыг нийт 2100,000 төгрөгөөр худалдан авч, дэмжин сурталчилж, 14 цэцэрлэгт тус бүр 1-ийг сургалтын зориулалтаар дэмжлэг болгосноор цэцэрлэгийн ахлах, бэлтгэл	2024.01.10 2024.12.10 80

						бүлгийн нийт 1873 хүүхэд морин хуурын анхан шатны сургалт авч байна.		
7.	Уугийн бичиг хөтөлхөх сургалтыг иргэдэд үе шаттай зохион байгуулан, түгээн дэлгэрүүлж, уугийн бичиг хөтөлдөг иргэдийн мэдээллийн сан бүрдүүлнэ.	Уугийн бичиг хөтөлтийг эрчимжүүлэх арга хэмжээний тоогоор	-	6		Учгийн бичиг хөтөлдөг иргэдийн судалгааг гаргаж угийн бичиг хөтөлхийн ач холбогдол, арга туршлага, тулгарах саад бэрхшээлийг давах арга барилын талаар энгийн иргэдийн туршлагаас олон нийтэд хүргэж сурталчлан Гэгээнтэн телевизтэй хамтран цуврал нэвтрүүлэг хийж байна. Хагас жилийн байдлаар тус нэвтрүүлэгт 11 дүгээр багийн иргэн Д.Наранцэцэг, 2 дугаар багийн иргэн С.Төмөрбаатар, 8 дугаар багийн Ж.Намхай иргэн нар оролцсон байна.	2024.02.10 2024.10.10	80
Зорилт 2. "АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРТАЛЧЛАХ МЭДЭЭЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1	Жуулчны бааз, амралтын газар, гэр буудлуудын холбогдох журам, стандартын хэрэгжилтэд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих	Хяналт шалгалтын тоогоор	-	1		Хэрэгжээгүй.	2024.01.10 2024.12.10	-
2	Тусгай зориулалтын аялал жуулчлал санаачлан зохион байгуулах аж ахуй нэгж, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах	Тусгай зориулалтын аяллын арга хэмжээний тоо, зочид жуулчдын тоогоор	-	-		Аваагын хүчтэн бөхийн холбоотой хамтран 2024 оны 05 сарын 10-12-ны өдрүүдэд анхны Үндэсний бөхийн 2024 оны "Хүүхдийн улсын аварга" шалгаруулах барилдааныг санаачлан зохион байгуулж 6 насны ангиллаар 19 аймаг, 6 дүүргийн 446 тамирчин ирж оролцсон. Мөн Буриад сурын харвааны "Улсын аварга" шалгаруулах уралдааныг аймгийн Сурын харвааны холбоотой хамтран 2024 оны 09 сарын 05-08-ны өдрүүдэд зохион байгуулж 11 аймаг, дүүргийн 63 харваач орон нутагт зочлон ирж оролцсон.	2024.01.10 2024.12.10	80
3	Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд хотын аяллын үзвэрээр виртуал аялал хийх	Виртуал аялал хийсэн байна.	-	1		Хотын аяллын гадна, доторх маршрутын дагуу түүх дурсгал, соёлын 18 үзвэрээр виртуал аяллыг "ЮНИКЕ ПОВЕР ТЕЧ" ХХК-иар гүйцэтгүүлэн хийлгэсэн.Тус виртуал аяллыг окулус төхөөрөмжөөр болон arvaikheer.ov.gov.mn сайтад байршуулан иргэдэд сурталчилсан.	2024.06.10 2024.10.10	100

4	Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын маршрутад түшиглэсэн соёлын үйлдвэрлэл болон брэнд бүтээгдэхүүн бий болгох	Шинээр бий болгосон брэнд бүтээгдэхүүний тоо	-	1	Төвийн бүсийн хотуудын туршлага солилцох уулзалт, арга хэмжээний үеэр 5 аймгийн 50 гаруй нутгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, өв соёлын модон эдлэл, суран эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүнүүдийг танилцуулсан.	2024.06.10 2024.12.10	80
---	---	--	---	---	---	--------------------------	----

Зорилт 3. БОЛЗОЛ ХАНГАСАН ИРГЭДИЙГ ШАГНАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Ерөнхийлөгчийн зарлиг "Монгол улсын цол хүртээх одон медалиар шагнах журам батлах тухай" журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Төрийн дээд одонгоор шагнуулах хүсэлт ирүүлсэн иргэдийг журмын дагуу хурлаар хэлэлцүүлэн уламжлах	Шаардлага хангасан, иргэдийн тоогоор	Шаардлага хангасан, иргэдийн тоогоор	Төрийн дээд одон, медальд тодорхойлон ирүүлсэн 218 иргэдийн материалыг хэлэлцэн шаардлага хангасан 213 иргэний материалыг аймгийн Засаг даргад уламжлан хүргүүлсэн. Өмнөх онуудад шагналд тодорхойлогдсон иргэдээс 122 шагнал дэмжигдэн ирүүлснийг зар хүргэж шагналыг гардуулсан. Алдарт эхийн 1 одонгоор 6, 2 дугаар одонгоор 133 иргэн шагнуулахаар болзол, шаардлага ханган ирүүлсэн материалыг хянан, уламжлан хүргүүлж бүрэн гардуулсан.	2023.01.10 2023.06.04	100
2.	"Арвайхээр сумын шагналын журам"-ыг хэрэгжилтийг хангаж ажиллах	Орон нутагт болон нийгэмд тустай амжилттай ажиллаж хөдөлмөрлөсөн иргэд, малчид, аж ахуй нэгж, байгууллагыг журмын дагуу шагнаж урамшуулах	Журманд заасан тоогоор, шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоогоор	Журманд заасан тоогоор, шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоогоор	2023 онд орон нутагтаа ажиллаж хөдөлмөрлөхдөө байгууллага, орон нутаг, нийгэмд тустай амжилт гаргасан: Тэргүүний байгууллага - 3 Нийгэмд тустай клуб - 2 Тэргүүний ажилтан - 11 Нийгэмд тустай иргэн - 8 иргэн Сумын аварга малчин - 10 өрх, Аварга саальчин - 1 Сумын алдарт уяач - 1 Тэргүүний фермер -1 Тэргүүний тариаланч - 3 тус тус шалгаруулан, шагнал гардуулж, амжилт хөдөлмөрийн нийтэд сурталчилсан.	2023.01.10 2023.06.10	100

ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрөн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, шийдвэрлэх тухай хууль,	Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь			Хагас жилийн байдлаар 6 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	2024.01.10 2024.11.10	100
----	---	---	--	--	---	--------------------------	-----

	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	100	100			
2.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах, хурал болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Уйл ажиллагааны үр дүнгээр	-	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан хагас жилээр тайлагнаж ажилласан байна	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд боловсруулж гүйцэтгэлийг хагас жилээр тайлагнасан.	2024.01.10 2024.11.20 100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
		1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны зөвлөлөөс тогтмол явуулдаг цахим сургалтанд хамрагдах (төрийн албаны сургалтын байгууллага)		Мэдлэг чадвараа дээшлүүлж өөрийгөө хөгжүүлсэн байх	-	10	Төрийн албаны зөвлөлийн цахим сургалтаас “Төрийн албан шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн”, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа сэдэвт сургалтуудад хамрагдсан.	2024.01.10 2024.11.10	30
2	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжих		Хууль, журмыг судлан өөрийн	-	1-2 хууль,	Төрийн албаны тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиуд, Соёлын өвийг хамгаалах тухай	2023.01.10 2023.06.10	100

		тэмдэглэн баяжилт хийсэн товч гарын авлагатай болсон байна.		2-3 дүрэм журам	хууль /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмуудыг уншин судалж, албан тушаалын шаардлагатай мэдлэг мэдлээллээ тогтмол сайжруулахад анхаарч, тэмдэглэл хөтөлж байна.		
3	Цахим хэрэглээний мэдлэг, чадвараа дээшлүүлэх	Мэдлэг чадвараа дээшлүүлж өөрийгөө хөгжүүлсэн байх	-	2	Төрийн байгууллагуудын удирдлагын нэгдсэн систем ERP систем, апп-ыг тогтмол үйл ажиллагаандаа ашиглаж, хэрэглээний чадвараа сайжруулж байна. CANVA программыг бие даан судалж албаны хэрэглээндээ ашиглаж байна.	2023.01.10 2023.06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)



..... / Н.МӨНГӨНГӨНЦЭЦЭГ /

(Нэр, гарын үсэг)

2024.11.25

(Огноо)